



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/392

Арвайхээр

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 14 дүгээр зүйлийн 14.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 04/02 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх үүргээ зөрчиж архи, согтууруулах ундаа худалдаалсан Баян-Өндөр сумын 5 дугаар багт үйл ажиллагаа явуулж буй Ө.Баянбилэг эзэмшигчтэй “Өгөөмөр” хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий зөрчил гаргасан дээрх худалдааны газарт хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), Баян-Өндөр сумын Засаг дарга (С.Чулууншагай)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100838